

Наурыз

Татейин ЕТЕКБАЙ



ISBN 995780457-X

9789997804525



00034833

5,000 ₸

Олон улсын наурын баяр

ТАБ
ТӨРӨГӨСӨН
99578045 99188004

ОЛОН УЛСЫН
НАУРЫЗЫН БАЯР

Татегийн ЕТЕКБАЙ
Соёл судлалын ухааны доктор (Ph.D)

**ОЛОН УЛСЫН НАУРЫЗЫН
БАЯР**

Дастан ХХК
Улаанбаатар хот 2017 он

ДАА 305.8
 ННА 63.5
 Е-88

ОРШИЛ

Дэлхийн соёл иргэншлийн түүхэнд Наурыз хэмээх ойлголт нэн эртнээс байраа эзэлжээ. Энэ ойлголтын нэр, агуулга, мөн чанарыг судлаад үзэхэд дорно зүгийн ард түмний ахуй амьдрал, баяр баясталан, итгэл үнэмшлийн тодорхой илэрхийлэл болж олон мянган жилийн тэртээгээс үүссэн өв соёлын тоонд багтдаг болох нь тодорхой байдаг. Өөрөөр хэлбэл Наурыз нь тэдгээр ард түмний жил солигдох мөчид тэмдэглэж ирсэн шинэ жилийн шинийн нэгний баяр юм. Энэ баярыг тодорхой улс орон бүр янз бүрийн нэрээр нэрлэж, янз бүрийн дэг жаягаар тэмдэглэж ирсэн түүхтэй ажээ. Наурыз бол өвлийн хахир хүйтэн цаг өнгөрч, хаврын сэтгэл тэнгйх дулаан цаг ирснийг, өдөр шөнийн үргэлжлэх хугацаа тэнцсэнийг заадагараа онцлог юм.

Өнөө үед Наурыз баярыг зөвхөн нэг улс, нэг үндэстэн төдий бус, дэлхийн олон улс оронд тэмдэглэдэг олон улсын хэмжээний томоохон баярын тоонд зүй ёсоор оржээ. Түүгээр ч барахгүй энэ баярыг олон улсын хэмжээний чухал баяр болохыг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганаар хүлээн зөвшөөрч, жил бүр гишүүн улс орнууд зохион байгуулалтын өндөр хэмжээнд тэмдэглэж байхыг уриалсан байна. ЮНЕСКО-гийн шийдвэрээр Наурызыг «Дэлхийн соёлын өв»-ийн материаллаг бус төрөлд бүртгэн авчээ. Иймээс НҮБ-ын гишүүн орны хувьд ч, энэ өдрийг үндэсний баярын хэмжээнд тэмдэглэж ирсэн ард түмний тодорхой хэсэг болох казах үндэстэн оршин суудгийн хувьд ч Монгол Улсын төр, засгаас сүүлийн жилүүдэд энэ баярт ач холбогдол өгч, анхаарал хандуулах болсон юм.

Наурыз баярыг Монголын казахууд 1937 он хүртэл ахан дүүс, төрөл садан, айл хотлоороо өргөн тэмдэглэж байжээ. Гэтэл 1937-1938 оны их хэлмэгдэл, баривчилгааны үеэс энэ баярыг шашны, үндэсний хоцрогдлын баяр хэмээн үзэж тэмдэглэхийг ор тас хорьсон байна. Харин 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд мартагдсан үндэсний ёс горим, зан заншил дахин сэргэх аз

Татегийн ЕТЕКБАЙ ОЛОН УЛСЫН НАУРЫЗЫН БАЯР

2017- 70 нүүр

Зохиогч энэхүү товхимолд Наурызын нэр томъёо, тодорхойлолт, дэлхийн ард түмэнтэй холбогдохын учир болон Наурызын баярын тухай казахын ард түмний дунд тархсан үлгэр домог, казах үндэстэн Наурызыг тэмдэглэж ирсэн уламжлал, ёс заншил, дэг жаяг, бэлэгдэл, казахын ард түмэн хэдийгээс тэмдэглэдэг болсон тухай дэлгэрэнгүй өгүүлжээ.

© ОЛОН УЛСЫН НАУРЫЗЫН БАЯР

E-mail: dastan_sep@yahoo.com

ISPN 978-99978-0-452-5

завшаан гарсны дүнд Наурыз баярыг казахын ард иргэд хаврын нарны баярын хувиар өргөн дэлгэр тэмдэглэх болсон юм.

Олон жилийн тэртээгээс үүссэн Наурыз баярын тухай ойлголт өнөө болтол тодорхой бус бүдэг байгаа учраас энэ баярын нэр томъёоноос эхлээд ойлголт, дэг жаяг, учир холбогдол, мөн чанарыг уншигчдад тайлбарлан таниулах зорилгоор миний бие «ОЛОН УЛСЫН НАУРЫЗЫН БАЯР» хэмээх товхимлыг уншигч олондоо толилуулж байна. Энэ товхимолд Наурызын тухай ил байгаа мэдээ, мэдээллийг нэг мөр болгон цэгцэлж боловсруулан бичлээ. Домгийн хэмжээнд байгаа зарим ойлголтууд цаашид ч судлагдаж улам тодорхой болох нь дамжиггүй. Эрхэм уншигч та таалан болгооно уу.

Хаврын сайхан нарны баяр – Наурызын илч гэгээ уншигч та бүхэнд ямагт эрч хүч, урам зориг хайрлаж, амьдрал ажил үйлсийг тань ивээж байх болтугай!

Зохиогч Талегийн ЕТЕКБАЙ

Соёл судлалын ухааны доктор (Ph.D)

I бүлэг. НАУРЫЗ – ОЛОН УЛСЫН БАЯР

I.1. Наурызын баярын нэр томъёо

Томоохон толь бичгүүдэд Наурызын баярыг дараах байдлаар тодорхойлжээ:

Наурызын баяр (Наурыз мейрамы) – Азийн ард түмний шинэ жилийг хүндэтгэж хийдэг баяр... *Казахын соёлын толь бичиг*

Наурыз – Азербайжан, Албани, Афганистан, Босни ба Герцеговин, Энэтхэг, Иран, Казахстан, Киргиз, Пакистан зэрэг оронд мөрддөг зодиакалын хуанли ёсоор хаврын эхлэл болон шинэ жил ирснийг тэмдэглэдэг баяр... *Википедия*

Навруз – Азербайжан, Албани, Афганистан, Босни ба Герцеговин, Энэтхэг, Иран, Казахстан, Киргиз, Пакистан зэрэг оронд мөрддөг зодиакалын хуанли ёсоор хаврын эхлэл болон шинэ жил ирснийг тэмдэглэдэг баярыг Наурыз гэдэг... *Википедия*

Навруз – Наурыз бол цэцэглэж буй мод... *Википедия*

Ноовруз – Азербайжан, Албани, Афганистан, Босни ба Герцеговин, Энэтхэг, Иран, Казахстан, Киргиз, Пакистан зэрэг оронд мөрддөг зодиакалын хуанли ёсоор хаврын эхлэл болон шинэ жил ирснийг тэмдэглэдэг баярыг Наурыз гэдэг... *Википедия*

Ноуруз – Азербайжан, Албани, Афганистан, Босни ба Герцеговин, Энэтхэг, Иран, Казахстан, Киргиз, Пакистан зэрэг оронд мөрддөг зодиакалын хуанли ёсоор хаврын эхлэл болон шинэ жил ирснийг тэмдэглэдэг баярыг Наурыз гэдэг... *Википедия*

Шинэ жил Казахстан – Казахстанд шинэ жил (казахаар Жаңа жыл) хоёр удаа тэмдэглэдэг: европын заншил ёсоор нэгдүгээр сарын 1-нд, мөн 3 дугаар сарын 22-нд хаваар өдөр шөнө тэнцсэн өдөр. Хоёр баярын аль нь төрийн баярын хэмжээнд тэмдэглэдэг... *Википедия*

Жүсип). Наурызнамагийн үеэр охид хөвгүүд нийлж «ноёрноос сэрээгч» (үйчидан ояту) бэлтгэдэг. Түүнийг нь борцолсон мах, уураг зэрэг амттай хүнсээр хийнэ. Залуучууд охид бүстгүүчүүдэд бөгж, ээмэг, толь, сам зэргийг бэлэглэдэг. Үүнийг «илбэсхийлгэх» (селт еткізер) гэж нэрлэнэ.

Наурызын өдөр явагдах урлаг, зан үйл, соёлын бүхий л арга хэмжээ энэ ойлголтын дор явагдана. Энэ өдөр аксакалууд үр удмынхаа санаа сэтгэлд мөнх үлдэх зөвлөгөөг хэлж, ариун ерөөлөө айлгана. Олноороо зөвшөөрсөн эрх бүхий хүн «наурызнамаг» нээнэ. Түүний дараа арьс булаалдах (көкбар), бүстгүй хөөх (кыз куар), хүзүүдэн унагаах (аударыспак), бөх (балуан), зургаан тулгуурт савлуурт тоглоом (алтыбақан), сүхий минь ол (балтамтал – эгэнэн сууж бие бие чичнэ, чичээгүй хүн *торгуль аена*), тэгнэ өргөх (тең көтеру), харилцаа дуу (айтыс), оньсого таах (жумбақ шешу), зоос харвах (теңге агу) зэрэг тоглоом наадам албан ёсоор эхэлж, цугларсан олон түмэн баярлаж талархана.

Бага үдийн алдад айлын хүмүүсгадаа гарч «тэмээн тогоон» доор гал түлнэ. Эрчүүд тогооны дэргэд шар авчирч нядална. Өдөр болоход хүмүүс өндөр доvon дээр дэлгэсэн дастархан-ы (дэлгэж тавьсан идээ будаа амттан) дэргэд цугларна. Энэ идээний дэвстэрийг «Эв нэгдлийн дастархан» гэж нэрлэнэ. Энэ өдөр настангуудад ч анхаарал хандуулна. Тэдэнд зориулж зөөлөн амтат хүнс оруулж «тэнхрүүлэх» хэмээн шарын хоёр чамирхай хийсэн тамир тэнхээ оруулах зорилготой хүндэтгэлийн таваг тавьж, үлдсэн хүмүүс хүндэтгэлийн хоолноос идэж, кеже ууна...

Нар мэхийх үеэр харилцаа дууны хоёр акын олны дунд гарч сайн ба муугийн, хүйтэн ба дулаарлын тэмцлийг дүрслэн харуулах «амьгүй ба амьтай» хоёрын харилцаа дууг аялж эхэлнэ. Энэ үед голд нь домгийн баатрууд болох «даарамттай эмгэн» ба түүний Акпан, Токпан нэртэй хоёр хүү, тэдэнтэй тэмцэхээр Ақборан, «Ёслон өглөгч» болон «Зөрүүд бүстгүүчүүд» гарч ирнэ. Харилцаа дуунд, нар шингэж орой болоход амьгүй нь ялагдаж, муу талын төлөөллүүд – даарамттай эмгэн болон Акпан, Токпан, Ёслон өглөгч нар зугатааж алга болно. Харанхуй бүрий болоход

хоёр газар гал түлж, залуучууд тал шөнөжингөө баярлаж цэнгэнэ.

Наурызын баяр. Наурыз – перс хэлэнд нэг л өдрийн нэр, шинэ жилийн шинийн нэгэн – шинэ өдөр. Казахын ард түмэнд хадгалагдсан ойлголт ёсоор энэ утгын зэрэгцээ шинэ оны эхний сарын нэрийг мөн бүтэн хамаардаг.

Казахын ард түмэн «Ард түмний их өдөр» хэмээн хүндэтгэдэг гуравдугаар сарын 22-ныг өдөр шөнийн урт тэндэг өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг Дорнын ард түмнүүдийн эртний гол баяр. Наурыз бол үндэсний уламжлалт ёс болон баяр цэнгэлийн бүх төрлийг хамарсан найр цэнгэл, шинэ жилийн баяр, хаврын баяр, өдөр шөнө хоёрын тэнцэх мөч, ард ирээдийн эв нэгдлийн өдөр юм. Наурыз байгалийн баяр. Өөрөөр хэлбэл, энэ бол уг баярыг тэмдэглэдэг ард түмнүүдийн хувьд маш том баясгалан, их цугларалт. Энэ өдрийг Дундад Ази болон казахууд «Самарканы хөх чулуу зөөлөрсөн өдөр» (Самарканның көк тасы жібiген күні) ч гэж хүндэтгэдэг. Наурыз казахуудын хувьд нэгдүгээр сарын нэр. Наурызын өдөр ард иргэд цэвэрхэн хувцаслаж, нэг нэгэндээ баяр хүргэж, баярын ширээгээ элбэг дэлбэг засна. «Улсын жолоо мэргэн байг!», «Цагаан идээ элбэг байг!», «Мал сүрэг мэнд байг!» гэх зэргээр хүсэлт гуйлт илэрхийлнэ. Хүмүүснэг нэгнийхээ алдааг уучилж, эвлэрнэ. Баярын сүүл тоглоом наадам, дуу хуураар үргэлжилнэ. Ард түмний дотор энэ өдөрт тохирсон ёс заншлууд бас байна. Тэдгээрийг «Наурызын баяр», «Наурызын магтаал», «Наурыз кеже», «Наурызын ерөөл» гэж нэрлэнэ. Энэ сард төрсөн хүүхдэд Наурызбай, Наурызхан, Наурызбек, Наурызтай, Наурызгүл, Наурызай, Наурызжан гэхчлэн нэр өгнө. Харамсалтай нь, өмнө нь энэ баярыг шашны баяр хэмээн үзэж Казахстанд ч, Монголын казахуудын хувьд ч тэмдэглэхийг зөвшөөрдөггүй байв. Казахын нэрт зохиолч Молдагали Жумабаев «Казахын Наурыз бол шашны баяр бус, амьдралын баяр, аж ахуйн баяр» гэжээ. 1990 оноос хойш энэ баярыг казах түмний уламжлалт баяр болгон жил бүр тэмдэглэх болов. Наурызыг жилээс жилд шинэ агуулга, хэлбэрээр баяжуулж, өргөн дэлгэр тэмдэглэж байгаа нь казах хүн бүрийн хүсэл сонирхолтой нийцэж, ард түмний

талархалыг хүлээдэг болжээ.

Наурызын сар. Дорно зүгийн улс орнуудын өдрийн тоолол ёсоор жилийн анхны сар. Григорианы өдрийн тоололд ч, жилийн анхны сарын тоололд ч өдөр ба шөнийн урт тэнцдэг. Тийм учраас наурыз жилийн эх болж тооцогдоно. Түүний зэрэгцээ өвлийн сүүл, хаврын эхлэл. Дулаарч, цас хайлж, хаврын шувууд ирж эхэлдэг. Тиймээс жилийн өлзийтэй улирлын хувьд ч наурызд бүх ард түмэн их хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ, түүнийг сар тооллын хүндтэй эхээр тооцдог ажээ.

Наурыз көже. Наурызын баярын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь наурыз көже (наурыз шөл) бэлтгэх явдал. «Наурыз шөл хүнсний зүйлийн долоон төрлөөс бэлтгэгдэнэ. Долоон төрлийн хүнсний зүйл ард түмний заншлаас үүдэлтэй... казах хэлний долоон овог, долоон баялаг, долоон давхар газар, долоон бурхан, долоон шене, “долоон хэрэгсэл” гэх мэт залгаа үгнүүд ард түмний эртний итгэл үнэмшил, домгийн, одон орны ойлголтуудаас үүсчээ. Тийм учраас зарим газарт көжөний бүрэлдэхүүн өөрчлөгдсөн ч, түүний бүрэлдэхүүн дэх хүнсний зүйлийн долоо байх нь зориуд хадгалагдсан»².

Ирж буй шинэ оныг элбэг дэлбэг байхыг бэлэгшээж, айл өрх бүр заавал хийдэг зориулалтын энэ хоолыг долоон төрлийн (улаан будаагай [шар будаа, цагаан будаа, арвайн будаа], мах, өөх, эрдэнэ шиш, сүү, ус, давс) зэрэг тэжээллэг хольц бүхий хүнсний зүйлээр бүрдүүлдэг байх нь чухал. Ааруул ба аарцын аль алийг нь сүүний оронд хэрэглэж болдог. Хольцын тоог хадгалж, идээний тоог нэмэгдүүлээд байж болно. Ер нь наурызын ширээний тавганд өвлийн идэшнээс үлдсэн казы, хиам, борцолсон мах зэрэг хүндэтгэлийн зохистой хүнс нэмдэг.

Наурыз көже хийхийн тулд юуны өмнө тогоо дүүрэн сүү хөөрүүлж, гарсан өрмийг ялгаж авна. Тэгээд сүүнд өвлийн турш хадгалсан борц махаа хийж, 15 минутын хугацаанд таглаад тавина. Энэ хугацаа өнгөрмөгц тустай саванд болгосон улаан буудай, эрдэнэ шиш, шар будаа, вандуй, будаа зэрэг хүнсний зүйлийн долоон төрлийг сүү, махтай хольж дахиад нэг удаа

буцалгана. Хэрэв Наурыз көже өггөрсөн байвал, түүнд ус хийж болохгүй. Зөвхөн тараг нэмж шингэрүүлнэ. Харин Монголын казахуудын хувьд сүүний оронд мах чанасан шөлийг түгээмэл хэрэглэдэг. Наурыз көжег ард түмний дунд «хүслийн көже» ч гэж нэрлэдэг явдал бий. Наурыз көже бол эртний өглөгч, зочломтгой, уужим сэтгэлт зэрэг үнэтэй заншлуудын нэг – идээ амсуулах сайхан ёс болж тогтжээ. Учир нь казахуудад «Нэг өдөр идээ амсахад, дөч хоног мэнд хүргэ» гэсэн гоё үг байдаг.

Наурызын магтаал. Ардын аман зохиолын баялаг хэлбэрүүдийн нэг бол – наурызын магтаал. Магтаалын дуу нь өнөө үетэй зохицож магтах, хүсэлт, ерөөл, инээдэм шог хэлбэрээр хэлэгдэнэ. Магтаалын төрлүүд ард түмний дотор элбэг тархсан байдаг. Наурызд зориулсан эртний болон өнөө үеийн зохиолч, яруу найрагчдын бүтээлүүд ч элбэг болжээ. Наурызын магтаал нь казахын ард түмний шинэ жил, Наурызд зориулж хэлдэг ахуй амьдралын магтаалын нэг төрөлд багтана. Наурызын магтаал (“Наурыз-жыры”), Эхийн ерөөл (“Жарапа-жан”) зэрэг дуу, магтаалд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөсөн хүмүүнлэг чанарыг илэрхийлдэг ажээ.

Энэхүү өдрийн тогоо чинь дүүрэн байвал,

Энэ жил чи цагталан байх болно.

Хэрэв чи Кыдыраас ивээл хүртсэн бол,

Хэзээ ч зам чинь өлзийтэй байх болно.

Хэзээ ямагт – Наурыз мөнх оршиг,

Хаврын шинээр сэргэсний баярт өдөр өө!

Наурызын ерөөл. Ард түмний дотор ерөөлийн төрөл олон. Түүний нэг нь – наурызын ерөөл юм. Наурызнама болоход наурыз баярт зориулж гаргасан малын толгой, сүүж болон хуучин оны идээний дээж – борцолсон казы, карта, жал-жая гэх зэрэгт, мөн наурыз көжөнд уригдагсадад, баярт зориулж урлагийн тоглолт хийсэн акын, дуучин, бөхчүүдэд болон уран сайханчдад, залуу уран бүтээлчдэд аксакалууд ба эмээ нар, ахмад хүмүүсээс зориулж айлтгах ерөөл үг юм. Ерөөлийг нийт ард иргэд, олон түмэн, айл өрх, хувь хүнд ч зориулж хэлж болдог. Тухайлбал,

Өнөр өтгөн болоорой!

2. «Қазақ ССР Қазақша энциклопедия», 4-том. Алматы, 1988, 672 дэх тал.

Өдөр болгон Наурызын өдөр шиг жаргалтай байг!

Хүү чинь ханиа олог, Охин чинь хадамд гараг!

Хүү чинь өрхийн эзэн, охин чинь гэрийн эзэгтэй болтугай!

Улсдаа нэргэй, түмэндээ нүүртэй байг!

Түмэндээ тустан, ардаа ачтан болог!

Санасан чинь бүтэг,

Хүсэл чинь биелэг!

Баруунаас чинь нар мандаж,

Зүүнээс чинь од гялалзах болтугай!

Од чинь онгойх!

Аз чинь гийх,

Ачтаны ивээл тусаг!

Төрийн жолоо зөв байг,

Түмэн олон амгалан байг!

Идээ цагаа элбэг байг,

Хүн ард цагталан байг! гэх зэргээр үргэлжилнэ.

Наурызын өдөр залуучууд томчуудаас ерөөл сонсохоор чармайдаг. Нөгөөтэйгүүр наурызын өдрийн ерөөлийн эзлэх байр онцгой. Иймд энэхүү ерөөлийг «уураг ерөөл» (уыз бата) хэмээн бэлэгшээдэг.

Наурызын оньсого. Байгаль, од гариг, цаг агаар, газар, өдөр ба шенетэй холбоотой хэлдэг оньсого ийнхүү нэрлэгддэг. Наурызын оньсого нь наурызын сарын оддын хөдөлгөөн ба байршил, өдөр ба шөнийн тэнцэл, байгалийн өөрчлөлт, энэ сард болох онцлог үйл явдал, цаг агаарын байдалтай холбоотой хэлдэг оньсого дуу юм. Яруу найрагчид, охид хөвгүүд дээрх сэдвүүдтэй холбоотой оньсогыг харилцаа дуунд оруулж уралддаг байжээ. Тухайлбал:

Замбуулинд нэгэн тарвас буй хатдаггүй,

Зунд нь ялзарч, өвөлд нь хөлддөггүй.

Байгаль дэлхийн уул, ус, ан амьтныг

Буйгаар нь дотор хийвэл дүүрдэггүй. (Тэнгэр, огторгуй)

Нэгэн хүн хүү, охин хоёртой юм,

Нийт дэлхий тэр хоёрыг андахгүй юм,

Хүү нь шене, охин нь өдөр нойр авна,

Хөрстөд явсан мөр нь үлдэхгүй юм. (Нар, сар)

Наурызын хүсэл. Хүн бүр өөртөө болон гэр орныхондоо эсвэл, ахан дүүс, найз нөхөддөө Ард түмний их өдрийн мэнд хүргэж, сайн сайхныг хүсдэг, нэг нэгнийдээ орж идээ амсдаг. Наурызын өдөр хүмүүс хоорондоо нүүр тулж, мэндлэх ёсоо гүйцэтгэн, баяр хүргэх үндсэн дээр шүлэглэж баярлах хүслээ хэлэхийг наурызын хүсэл гэдэг. Жишээ нь:

«Сүрэг малын тань сүү элбэг байг! Бэлчээр тань малаар, гэр тань хүүхдээр дүүрэг!». Хүсэл нөхөрсөг сэтгэл, хүн чанарын илэрхийлэл, баяр бүрийн зохистой ёсны нэг болж хэлэгдэнэ. «Хөх тэнгэр гэгээгээ бүү харамла, Газрын тэнгэр хишгээ бүү харамла! Үнэнч шударга хүнийг суудлаас нь бүү хөдөлгө, Үй олон ардыг азаас нь бүү салга! Ам бүлд минь хүн нэм, Алд биед минь нас нэм, Амжиргаанд минь хүнс нэм!». Ийм сайн сайхныг ам бүл бүхэн өөрийн өрх гэртээ алгаа дэлгэн үнэн санаанаасаа, ариун сэтгэлээсээ хүсдэг.

Наурызын төл. Наурыз сард мал төллөж эхэлдэг. Наурыз сард гарсан ботго, унага, тугал байвал наурыз төл гэж нэрлэнэ. Тэрхүү наурыз төлийг «толгой төл» хэмээн хүндэтгэн үзэж, малд хайртай казах хүн бүр түүнийг онцгой тэжээж асардаг. Ийм малыг тэр айл өрх бусдад зарахгүй, өөр малаар солихгүй, гол төлөв өөрийн хэрэгцээ, онцгой баярт үйл явдалд зориулж хэрэглэнэ.

Наурыз хөх. Наурыз сард нисэж ирдэг хаврын шувуу. Хөх өнгө нь давамгайлсан жижигхэн хөх шувуу. Энэ шувууг дорнын ард түмэн онцгойлон хүндэтгэнэ. Түүнийг анх харсан хүн «Наурыз хөх минь ирсэн үү» гэж дуудна. Наурыз хөхийг хэн ч үргээдэггүй, түүнийг хийморьтой шувуудын тоонд оруулдаг.

Наурыз цэцэг (Наурыз шешек). Наурыз сард цэцэглэдэг, навчтай, янз бүрийн өнгөтэй цэцэг бүхий олон наст гоё ургамал. Гоо сайхныг нь эрхэмлэн гэрт ургуулж болдог. Тос нь эмчилгээний шинж чанартай. Өндөр Алтайн нуруунд түүний олон төрөл ургадаг. Наурыз шешек «Улаан номд» орсон, ховордсон ургамлын тоонд багтдаг.